210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,328,913,532.07	2,481,800,600.00	2,382,032,212.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,717,018.23	82,013,300.00	72,076,134.00
210803	Даатгалын үйлчилгээ	19,610,944.00	22,754,100.00	21,107,055.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,600,834.50	9,414,500.00	6,944,234.00

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,284,234.00	2,856,300.00	1,902,771.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	215,111,269.00	16,946,100.00	14,624,201.00
210807	Газрын төлбөр	4,631,894.00	7,810,300.00	5,990,714.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,406,562.00	1,764,000.00	862,518.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0	10,382,000.00	6,918,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,338,482,022.13	4,320,720,000.00	3,803,627,051.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,645,086,856.13	3,556,968,000.00	3,059,545,472.24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	693,395,166.00	763,752,000.00	744,081,578.84
212	ТАТААС	13,780,000.00	7,473,600.00	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	13,780,000.00	7,473,600.00	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	13,780,000.00	7,473,600.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,200,829,956.00	1,385,055,800.00	1,344,424,964.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,829,956.00	1,385,055,800.00	1,344,424,964.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж			
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	127,100,000.00	89,300,000.00	86,300,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	68,487,300.00	32,130,400.00	32,107,496.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	383,739,896.00	717,255,600.00	694,348,540.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	563,104,260.00	448,847,400.00	436,665,328.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	58,398,500.00	97,522,400.00	95,003,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,179,341,528.79	7,145,610,100.00	5,233,041,174.40
2200	Дотоод эх үүсвэрээр	6,179,341,528.79	7,145,610,100.00	5,233,041,174.40
223001	Бусад хөрөнгө	6,179,341,528.79	7,145,610,100.00	5,233,041,174.40
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,390,569,886.00	2,262,699,000.00	1,323,935,890.00
230001	Эргэж төлөгдөх зээл	1,390,569,886.00	2,262,699,000.00	1,323,935,890.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	76,746,460,746.05	85,061,554,400.00	81,760,601,028.88
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,431,143,973.94	46,305,741,000.00	45,524,087,545.14
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	42,431,143,973.94	46,305,741,000.00	45,524,087,545.14
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,337,172,835.91	33,453,754,700.00	33,511,903,540.04
132001	Орон нутгийн төсвөөс	28,060,381,101.91	27,466,134,100.00	27,524,282,934.04
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	4,276,791,734.00	5,987,620,600.00	5,987,620,606.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	338,798,672.00	515,706,800.00	318,362,634.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	338,798,672.00	515,706,800.00	318,362,634.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,639,345,264.20	4,786,351,900.00	2,406,247,309.70
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,615,745,564.20	1,746,413,400.00	2,404,191,509.70
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,599,700.00	0	2,055,800.00
1E+06	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0	3,039,938,500.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,183,109,960.98	-	1,472,729,504.47
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,472,852,736.94	-	3,310,494,338.79
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	171.00	173.00	173.00
610001	Төсвийн байгууллага	171	173	173
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	3,584.00	3,822.00	3,834.00

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

620001	Удирдах ажилтан	315	344	348
620002	Гүйцэтгэх ажилтан	2,195.00	2,360.00	2,383.00
620003	Үйлчлэх ажилтан	992	1,035.00	1019
620004	Гэрээт ажилтан	82	83	84
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	20,420.00	20,934.00	16,747.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	14,653.00	15,027.00	11,121.00
630001	Төрийн өмчит ЕБС	14,653.00	15,027.00	11,121.00
630002	Хувийн ЕБС			
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	5,767.00	5,907.00	5,626.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	5,767.00	5,907.00	5,626.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3,584.00	3,822.00	3,642.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	344	388	378
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3	3	3
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	2,234.00	2,338.00	2,153.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	221	222	221
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	313	402	404
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	196	212	239
650010	Гэрээт ажилтан	75	73	69
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	198	184	175

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,664,282,066.74	6,745,857,262.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,132,341,456.74	6,330,017,172.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,734,168,330.74	3,980,901,202.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,846,766.38	366,832,347.81
210101	Үндсэн цалин	91,388,005.32	190,722,811.84
210102	Нэмэгдэл	335,850.00	5,343,262.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	675,092.00	94,564,773.28
210105	Гэрээт ажлын хөлс	72,447,819.06	76,201,500.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,125,739.08	28,715,923.01
210201	Тэтгэврийн даатгал	9,644,622.08	27,219,759.55
210202	Тэтгэмжийн даатгал	118,935.00	334,064.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	85,445.00	212,287.09
210204	Ажилгүйдлийн даатгал	10,910.00	33,194.05
210205	Эрүүл мэндийн даатгал	1,265,827.00	916,617.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,279,433.25	60,480,138.89
210301	Гэрэл, цахилгаан	1,564,446.16	4,249,595.89
210302	Түлш, халаалт	36,650,137.09	40,125,733.00
210303	Цэвэр, бохир ус	1,064,850.00	16,104,810.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	97,757,586.57	175,427,128.61
210401	Бичиг хэрэг	11,964,723.00	26,584,429.43
210402	Тээвэр, шатахуун	46,586,233.20	91,246,543.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,191,506.08	5,400,450.00
210404	Ном, хэвлэл	9,415,460.00	12,859,858.18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,020,341.00	6,779,908.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,579,323.29	32,555,940.00

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

2105	Нормативд зардал	347,941,871.39	703,999,227.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	331,123,191.69	623,656,650.72
210502	Хоол, хүнс	11,000,586.00	77,898,777.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,818,093.70	2,443,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,109,560.00	163,732,843.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,258,300.00	33,641,400.00
210602	Тавилга	0	6,900,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,850.00	0
210604	Урсгал засвар	53,550,410.00	123,191,443.00
2107	Томилолт, зочны зардал	1,077,900.00	16,425,800.00
210702	Дотоод албан томилолт	1,077,900.00	16,425,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	1,272,741,275.07	497,695,697.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,270,223,525.07	484,301,091.58
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	628,500.00	1,260,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0	32,348.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,455,000.00	325,800.00
210807	Газрын төлбөр	352,950.00	213,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	51,300.00	11,562,358.23
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	30,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,744,288,199.00	1,967,592,095.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,681,067,669.00	1,593,389,665.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,220,530.00	374,202,430.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	384,393,126.00	2,349,115,969.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	315,650,866.00	1,627,321,931.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	468,008.00	0
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	13,048,685.00	0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	1,600,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	263,859.00	1,041,550.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	28,848,640.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	282,373,164.00	856,557,518.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,497,150.00	739,274,223.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	68,742,260.00	721,794,038.41
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	68,742,260.00	721,794,038.41
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,531,940,610.00	415,840,090.50
2200	Дотоод эх үүсвэрээр	1,531,940,610.00	415,840,090.50
223001	Бусад хөрөнгө	1,277,615,800.00	139,161,397.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	254,324,810.00	276,678,693.50
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,805,096,408.78	7,235,557,950.57
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,805,096,408.78	7,235,557,950.57
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,788,917.00	32,254,940.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,976,200.00	207,329,509.09
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	1,292,613,901.28	3,759,529,528.76
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,461,717,390.50	3,122,855,062.72
131106	Төсвийн урамшуулал		113,588,910.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	140,814,342.04	489,700,687.82
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	187,787,661.44	328,602,003.48
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	328,602,003.48	818,302,691.30

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Жалбаа, аудитор Ц.Оюунсүвд нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүллээ.

Завхан аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 5/371 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зорилго, зорилтоо “Халдварт цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулж, эдийн засаг, нийгэм, хүний хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, бүс ба орон нутгийг хөгжүүлэх” гэж тодорхойлсон байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 6 бүлэг, 26 зорилтын хүрээнд 244 арга хэмжээг төлөвлөжээ. Үүнд:

- “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжин, тамирчдын тив, дэлхий, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.
- Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон, насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлнэ.
- Судалгааны ажлыг үр дүнтэй зохион байгуулж, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх үр ашгийг нэмэгдүүлсэн байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэж, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжин амьдралын чанарыг дээшлүүлнэ.
- Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлэн, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрд хүрсэн, дундаж давхарга зонхилсон, эдийн засгийн суурийг бүрдүүлж, хөрөнгө оруулалт хуримтлалын чадавхаа бэхжүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай аймаг болно.
- Байгальд ээлтэй технологи бүхий ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.
- Бэлчээрийн даацад нийцсэн ашиг шим өндөртэй эрүүл малыг өсгөн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг өргөжүүлнэ.

- Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- Улсын болон орон нутгийн авто замын сүлжээг өргөжүүлнэ.
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлагыг хэрэгжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.
- Төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгоно.
- Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.
- Гадаад бодлого, харилцаа хамтын ажиллагааг тогтвортой хэрэгжүүлнэ.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ.
- Байгалийн нөөцийг хамгаалж, нөхөн сэргээж, зохистой ашиглалтыг бий болгоно
- Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан, бүс, орон нутаг, төв суурин газрын төлөвлөлтийг оновчтой хийнэ.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 25 дугаар тогтоолоор 81.2 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын шилэн данс болон 84 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт, Сангийн сайдын удирдамжаар 2, өргөдөл гомдлоор 19 төлөвлөгөөт бус, нийт 103 байгууллагад хяналт шалгалтыг хийж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах үүргийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн явцад улирал бүр дотоод аудит хийж, мэдээлэл байршуулаагүй, тайлан удаа дараа илгээгээгүй 4 албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, зөрчил арилгуулах саналыг төсвийн шууд захирагчид хүргүүлжээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад Аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын нэгжийн хяналт үр дүн, үр нөлөө хангалтгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 226,929.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2,269.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,588.5 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитыг гүйцэтгэх шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,628.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 18,843.5 сая төгрөг болж, өмнөх оноос 12,215.5 сая төгрөгөөр буюу 184.3 хувиар өссөн байна. Тайлант оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 2.3 сая төгрөг буюу 0.01 хувь нь касст байгаа бэлэн мөнгө, 18,604.3 сая төгрөг буюу 98.73 хувь нь төрийн сан болон нэмэлт санхүүжилтийн харилцах, 236.9 сая төгрөг буюу 1.26 хувь нь арилжааны банканд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Хүснэгт 1

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Касст байгаа бэлэн мөнгө	Банканд байгаа бэлэн мөнгө		Өсөлт (+) Бууралт (-)
				Арилжааны банк	Төрийн сангийн харилцах	
Касст байгаа бэлэн мөнгө төгрөг/ЖМС	10.7	2.3	2.3	-	-	-8.4
Төрийн сангийн харилцах	6,252.6	17,788.0			17,788.0	+11,535.4
Арилжааны банк дахь харилцах	36.1	236.9		236.9		+200.8
Нэмэлт санхүүжилтийн харилцах	328.6	816.3	-	-	816.3	+487.7
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	6,628.0	18,843.5	2.3	236.9	18,604.3	+12,215.5
Байгууллагын төрлөөр						
Төрийн сангийн харилцах	4,062.5	7,914.4				3,851.9
Төсөвт байгууллагууд	1,489.4	3,382.7				+1,893.3
Төсөл, сан	1,065.7	7,315.7				+6,250.0
ОНӨААТҮГ	10.4	230.7				+220.3
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	6,628.0	18,843.5				+12,215.5

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 42 хувь буюу 7,914.4 сая төгрөгийг төрийн сангийн, 18 хувь буюу 3,382.8 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 38.8 хувь буюу 7,315.7 сая төгрөгийг төсөл, сангийн, 1.2 хувь буюу 230.6 сая төгрөгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үлдэгдэл тус тус эзэлж байна.

Касст байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл 2.3 сая төгрөг нь аймгийн Хөгжимт жүжгийн театрын үлдэгдэл байна.

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

Арилжааны банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл өмнөх оноос 200.8 сая төгрөгөөр өсөж, тайлант онд 236.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд 97.4 хувийг ОНӨААТҮГ-ийн үлдэгдэл, 2.6 хувийг төсөвт байгууллага эзэлж байна.

Арилжааны банкинд дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Хүснэгт 2

Байгууллагын нэр	Үлдэгдэл		Нийт үлдэгдэл	Байгууллагын тоо
	Харилцах данс	Хугацаатай хадгаламж		
Төсөвт байгууллага	6.2	-	6.2	2
ОНӨААТҮГ	230.7	-	230.7	6
Нийт дүн	236.9		236.9	8

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын арилжааны банкны үлдэгдэл 6.2 сая төгрөг байгаа нь Хот тохижилт үйлчилгээний алба, аймгийн төвийн өрхийн эмнэлгүүдийн харилцах дансны үлдэгдэл байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант оны эхэнд 4,062.5 сая төгрөг, оны эцэст 7,914.4 сая төгрөг болж, өмнөх оноос 3,851.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Хүснэгт 3

№	Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	Завхан аймаг	1,679.5	4,085.6	2,406.1	51.6
2	Алдархаан	102.1	216	113.9	2.7
3	Асгат	37.5	46.7	9.2	0.6
4	Баянтэс	54.3	38.8	-15.5	0.5
5	Баянхайрхан	41.5	91.3	49.8	1.2
6	Дөрвөлжин	187.2	205.3	18.1	2.6
7	Завханмандал	15.4	31.9	16.5	0.4
8	Идэр	64.9	95.3	30.4	1.2
9	Их Уул	359.6	204.9	-154.7	2.6
10	Нөмрөг	83.4	90.4	7	1.1
11	Отгон	47.4	124.6	77.2	1.6
12	Сантмаргац	109.3	162.1	52.8	2
13	Сонгино	61.7	604.4	542.7	7.6
14	Тосонцэнгэл	166.8	125.4	-41.4	1.6
15	Тэс	31.8	23.8	-8	0.3
16	Тэлмэн	90.6	190.9	100.3	2.4
17	Түдэвтэй	105.1	454.5	349.4	5.7
18	Улиастай	360.2	5.3	-354.9	0.1
19	Ургамал	117.4	207.5	90.1	2.6
20	Цэцэн-Уул	69.1	88.5	19.4	1.1
21	Цагаанхайрхан	19.5	49.8	30.3	0.6
22	Цагаанчулуут	40.6	48.1	7.5	0.6
23	Шилүүстэй	49.9	418.1	368.2	5.3
24	Эрдэнэхайрхан	121.7	158.7	37	2
25	Яруу	45.8	146.9	101.1	1.9
Төрийн сангийн үлдэгдэл		4,062.5	7,914.4	3,851.9	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгө

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1,893.3 сая төгрөгөөр өсөж, тайлант онд 3,382.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь сум хөгжүүлэх сан 1,498.6 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сан 1,794.8 сая төгрөг, сумдын ЭМТ, өрхийн эмнэлгүүдийн харилцах дансны үлдэгдэл 78.9 сая төгрөг эзэлж байна.

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Хүснэгт 4

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

Салбар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутаг	1,475.3	3,303.8	1,828.5	97.7
Үүнээс: ОНХС	898.2	1,794.8	896.6	53.1
СХС	573.6	1,498.6	925.0	44.3
Төсөвт байгууллагууд	3.5	10.4	6.9	0.3
Боловсрол шинжлэх ухааны яам	-	-	-	-
Эрүүл мэндийн яам	14.1	78.9	64.8	2.3
Нийт дүн	1489.4	3,382.7	1,893.3	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөл, сангийн мөнгөн хөрөнгө

Төсөл, сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 6,250.0 сая төгрөгөөр өсөж, тайлант онд 7315.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарснаас 6,564.3 сая төгрөг нь аймаг хөгжүүлэх сан буюу улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний барьцаа, техник хяналтын зардлын үлдэгдэл, 751.4 сая төгрөг нь бусад сан буюу төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө байна.

Төсөл, сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Хүснэгт 5

Байгууллагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Аймаг хөгжүүлэх сан	740.6	6,564.3	+5,823.7	89.7
Бусад сан	325.1	751.4	+426.3	10.3
Нийт дүн	1,065.7	7,315.7	+6,250.0	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ОНӨААТҮГ-ын мөнгөн хөрөнгө

ОНӨААТҮГ-ийн харилцах дансны үлдэгдэл 230.6 сая төгрөг бөгөөд “Амь-Ус трейд” ХХК-ийн үлдэгдэл 215.5 сая төгрөг, “Тосон-Очирт хайрхан” ОНӨААТҮГ 12.3 сая төгрөг, бусад ОНӨААТҮГ-уудийн үлдэгдэл 2.9 сая төгрөг байна.

ОНӨААТҮГ-ын мөнгөн хөрөнгө /сая төгрөгөөр/

Хүснэгт 6

Байгууллагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
“Амь-Ус трейд” ХХК	5.9	215.5	+209.6	93.4
“Тосон-очирт хайрхан” ОНӨААТҮГ	1.5	12.3	+10.8	5.3
Бусад ОНӨААТҮГ	3.0	2.9	-0.1	1.3
Нийт дүн	10.4	230.7	+220.3	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагатай холбоотой аудитын илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын авлагын данстай холбоотой алдаа, зөрчлүүдээс дурдвал:/ ТШЗ-ийн/

- Төсөвт 4 байгууллага няравын хувийн дансаар бэлэн мөнгө дамжуулан зарцуулсан, няравын тайлан хөтлөлт хангалтгүй 74.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2 байгууллагад 10.8 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлж, 1 байгууллагын 1.2 сая төгрөгийн алдааг залруулж, 4 байгууллагад 8.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.
- Няравын данснаас мөнгө дутагдсан, хувийн дансаар дамжуулсан зарцуулалтын анхан шатны баримт хангалтгүй, бэлэн мөнгөний тайлан тооцоог тухай бүр хийж гарын үсэг зуруулдаггүй нийтлэг алдаа, зөрчил илэрсэн байна.

3.5.2 Авлага

Авлагын дансны эхний үлдэгдэл 6,601.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,811.0 болж, 749.5 сая төгрөгөөр өссөн бөгөөд нийт авлагын 71.1 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Нийт авлага /сая төгрөгөөр/

Хүснэгт 7

Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой авлага	59.0	100.0	+41.0	1.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	153.9	488.0	+334.1	7.2
Байгууллагаас авах авлага	143.1	384.1	+241.0	5.6
Дансны авлага /ТӨҮГ/	106.1	171.1	+65.0	2.5
Татвар НДШ -ийн авлага /ТӨҮГ/	4.1	1.3	-2.8	0.0
Татаас санхүүжилтийн авлага	-	714.5	+714.5	10.5
Хувь хүнээс авах авлага	5,595.3	4,952.0	-643.3	72.7
Нийт дүн	6,061.5	6,811.0	+749.5	100
Байгууллагын төрлөөр				
Төсвийн байгууллага	5,715.0	6,411.3	+696.3	94.1
Төрийн сан	153.6	153.6	-	2.3
Төсөл сан	41.5	41.5	-	0.6
ОНӨААТҮГ	151.3	204.5	+53.2	3.0
Нийт дүн	6,061.5	6,811.0	+749.5	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 94.1 хувийг төсвийн байгууллага, 2.3 хувийг төрийн сан, 0.6 хувийг төсөл сан, 3 хувийг ОНӨААТҮГ-ын авлага тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагын 6,411.3 сая төгрөгийн авлагын 4,846.6 сая төгрөг буюу 75.6 хувь нь сум хөгжүүлэх сангийн, 74.5 сая төгрөг буюу 1.2 хувь нь сумдын ОНХС-ийн, 201.5 сая төгрөг буюу 3.1 хувь нь орон нутгийн төсөвт байгууллагуудын, 57.8 сая төгрөг буюу 0.9 хувь нь боловсролын салбарын байгууллагуудын, 1,224.3 сая төгрөг буюу 19.1 хувь нь эрүүл мэндийн салбарын байгууллагын, 6.6 сая төгрөгийн 0.1 хувь нь хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын байгууллагын авлага байна.

Төсөвт байгууллагын авлага /сая төгрөгөөр/

Хүснэгт 8

Салбар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутаг	5,602.1	5,122.6	-479.5	79.9
Үүнээс: ОНХС	1.2	74.5	+73.3	1.2
СХС	5505.3	4,846.6	-658.7	75.6
Төсөвт байгууллагууд	102.1	201.5	+99.4	3.1
БШУ-ны яам	80.2	57.8	-22.4	0.9
Эрүүл мэндийн яам	29.0	1,224.3	+1,195.3	19.1
Барилга хот байгуулалтын яам	0.2	-	-	
Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	3.5	6.6	+3.1	0.1
Нийт дүн	5,715.0	6,411.3	+696.3	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын авлагад аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар өмнөх оны санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн 55.6 сая төгрөгийг тайлант онд байгууллагаас авах авлагаар тусгаж тайлагнасан байна. Тус байгууллагын 55.6 сая төгрөгийн авлага нь 2020 онд үүссэн он дамжсан авлага бөгөөд ажил гүйцэтгүүлэхээр 2 байгууллагатай

гэрээ байгуулж, урьдчилгаа санхүүжилт олгосон боловч тухайн ажлууд бүрэн хийгдээгүй, хийгдсэн ажлууд шаардлага хангахгүйн улмаас авлагаар тусгагдсан байна.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аймгийн БОАЖГ-ын 2020 онд үүссэн он дамжсан 55.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар өмнөх оны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Иймд дээрх зөрчилд аймгийн БОАЖГ-т албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн авлага 2021 оны эцэст 4,846.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь өмнөх оноос 658.7 сая төгрөгөөр буюу 12 хувиар буурсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага /сая төгрөгөөр/

Хүснэгт 9

д/д	Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	Алдархаан	221.2	231.2	-10.1	4.8
2	Асгат	177.2	111.8	65.4	2.3
3	Баянтэс	183.3	149.5	33.8	3.1
4	Баянхайрхан	217.5	213.4	4.2	4.4
5	Дөрвөлжин	152.3	204.1	-51.8	4.2
6	Завханмандал	199.3	146.6	52.7	3.0
7	Идэр	181.7	156.6	25.1	3.2
8	Их-Уул	234.7	232.3	2.4	4.8
9	Нөмрөг	164.0	144.3	19.7	3.0
10	Отгон	166.1	130.6	35.5	2.7
11	Сантмаргаз	183.7	165.0	18.8	3.4
12	Сонгино	130.1	114.3	15.8	2.4
13	Тосонцэнгэл	497.8	472.6	25.2	9.8
14	Тэс	193.8	139.1	54.6	2.9
15	Түдэвтэй	180.4	119.4	61.1	2.5
16	Тэлмэн	131.8	114.2	17.6	2.4
17	Улиастай	978.2	836.8	141.4	17.3
18	Ургамал	181.4	144.2	37.2	3.0
19	Цэцэн-Уул	205.3	126.7	78.6	2.6
20	Цагаанхайрхан	166.8	176.1	-9.4	3.6
21	Цагаанчулуут	235.2	227.3	7.9	4.7
22	Шилүүстэй	209.4	152.5	56.9	3.1
23	Эрдэнэхайрхан	130.8	169.5	-38.7	3.5
24	Яруу	183.2	168.6	14.6	3.5
Нийт дүн		5,505.3	4,846.6	-658.7	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2021 онд “Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулахаар зохион байгуулсан ажлын үр дүн”-д эрсдэлийн аудит хийж, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлээгүй, 24 сумын хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд 229.2 сая төгрөгийн алданги тооцож, хугацаа хэтэрсэн зээлдэгчдийг шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэн, авлагыг барагдуулах талаар албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын хугацаа болоогүй, хэрэгжих шатандаа байна.

Сумын ОНХС-ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй авлага өмнөх оноос 73.2 сая төгрөгөөр нэмэгдэж, эцсийн үлдэгдэл 74.5 сая төгрөг болсон нь ажил гүйцэтгүүлэхэд олгосон урьдчилгаа санхүүжилт байна.

Сумдын ОНХС-ийн авлага /сая төгрөгөөр/

Хүснэгт 10

Сумдын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)	Эцсийн үлдэгдлийн бүтэц
				Ажил гүйцэтгүүлэхэд олгосон урьдчилгаа санхүүжилт
Аймгийн ОНХС	1.3		-1.3	
Идэр	-	58.5	+58.5	58.5
Тэс	-	16.0	+16.0	16.0
Дүн	1.3	74.5	+73.2	74.5

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Идэр сумын ОНХС-аас мал угаалгын суурин ванн байгуулах ажлыг “Энх мөнх ирээдүй” ХХК-аар гүйцэтгүүлэхээр 14.0 сая төгрөгийн, сумын тохижилт, гэрэлтүүлэг, хайс шинэчлэлийн ажлыг “Joint Саксес” ХХК-аар гүйцэтгүүлэхээр урьдчилгаа 44.5 сая төгрөгийн, Тэлмэн сумын ОНХС-аас угтах хаалга хийх ажлыг иргэдийн бүлгээр гүйцэтгүүлэхээр урьдчилгаа 16.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож, хөрөнгө оруулалтын ажил бүрэн хийгдэж, хүлээж аваагүй, он дамжин хэрэгжиж байгаа зэргээс шалтгаалан шинээр үүссэн авлага байна.

Төрийн сангийн авлага

Аймгийн төрийн санд олон жил он дамжсан, 20 гаруй жилийн насжилттай 153.6 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна.

Төсөл сангийн авлага

Төсөл сангийн 41.5 сая төгрөгийн авлага нь Орон нутгийн хөрөнгө оруулалтаар он дамжин хийгдсэн ажлын техник хяналтын зардлыг барьцаа хөрөнгийн данснаас зарцуулсныг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас барьцаа хөрөнгийн дансанд буцаан төвлөрүүлэх авлага байна.

ОНӨААТҮГ-ын авлага

ОНӨААТҮГ-ын авлага өмнөх оноос 53.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 204.5 сая төгрөг болсон байна. “Амь-Ус трейд” ХХК-ийн авлага 40.2 сая төгрөгөөр, “Тосон-очирт хайрхан” ОНӨААТҮГ-ын авлага 17.5 сая төгрөгөөр өссөн нь нөлөө үзүүлж байна. Тус авлага нь ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны хүрээнд бий болсон байна.

ОНӨААТҮГ-ын авлага /сая төгрөгөөр/

Хүснэгт 11

Байгууллагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
“Амь-Ус трейд” ХХК	62.2	102.4	+40.2	50.1
“Тосон-очирт хайрхан” ОНӨААТҮГ	42.8	60.3	+17.5	29.5
“Очир илч” ОНӨААТҮГ	39.9	32.9	-7.0	16.1
Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв	5.5	8.9	+3.4	4.3
“Шинэ дөрвөлжин” ОНӨААТҮГ	1.0		-1.0	
Нийт дүн	151.3	204.5	+53.2	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагатай холбоотой аудитын илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын авлагын данстай холбоотой алдаа, зөрчлүүдээс дурдвал:

- Тооцоо нийлсэн актаар баталгаажгаагүй авлагыг илүү болон дутуу дүнгээр тусгасан, оны эцэст цалин болон эм, шатахуун, бусад зардлын хэмнэлтийг төвлөрүүлэхгүй авлага үүсгэсэн 146.6 сая төгрөгийн алдааг залруулж, 2.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэн, 52.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 584.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- Мөн 2021 онд ковидоор өвчилсөн иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын хэмнэлт буюу тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдлийг төсвийн дараагийн жилд

үргэлжлүүлэн зарцуулахаар авлага үүсгэсэн 17 сумын Эрүүл мэндийн төвд нийт 566.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 57.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3.0 сая төгрөг болж, өмнөх оноос 54.5 сая төгрөгөөр буурсан байна.

Урьдчилгаа /сая төгрөгөөр/

Хүснэгт 12

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Буурсан (-)	Хувь
Урьдчилж гарсан зардал	56.6	3.0	-53.6	100
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0.5	-	-0.5	-
Цалингийн урьдчилгаа	0.4	-	-0.4	-
Урьдчилж гарсан зардал				
Дүн	57.5	3.0	-54.5	100
Байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	56.5		-56.5	
ОНӨҮГ	1.0	3.0	2.0	100
Дүн	57.5	3.0	-54.5	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

“Тосон-очирт хайрхан” ОНӨААТҮГ-ын 1.0 сая төгрөг, Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албаны 2.0 сая төгрөгийн урьдчилж гарсан зардал байна.

3.5.4 Бараа материал

Бараа материал дансны эхний үлдэгдэл 7,248.6 сая төгрөг, тайлант оны эцэст үлдэгдэл 8,052.9 сая төгрөг болж, 9.98 хувиар буюу 804.3 сая төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материал, эм боох материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материал гол нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 13

Бараа материал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Буурсан (-)	Дунд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	905.7	999.8	+94.1	12.4
Эм боох материал	225.0	387.5	+162.5	4.8
Бэлэн бүтээгдэхүүн	64.9	79.1	+14.2	1.0
Бичиг хэргийн материал	282.81	272.7	-10.0	3.4
Аж ахуйн материал	1953.0	2,177.8	+224.8	27.0
Сэлбэг хэрэгсэл	46.2	68.2	+22.0	0.8
Түлш, шатах тослох материал	311.8	249.9	-61.8	3.1
Барилгын засварын материал	167.0	187.1	+20.0	2.3
Хүнсний материал	464.7	496.5	+31.7	6.2
Бусад хангамжийн материал	2,572.1	2,940.1	+367.9	36.5
Мал амьтад	254.8	193.6	-61.1	2.4
Дүн	7,248.6	8,052.9	+804.3	100
Байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	7,053.0	7,856.6	+803.6	97.6
ОНӨААТҮГ	195.6	196.3	+0.7	2.4
Дүн	7,248.6	8,052.9	+804.3	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн 97.6 хувийг төсөвт байгууллага, 2.4 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал тус тус эзэлж байна.

Бараа материалын өөрчлөлт /сая төгрөгөөр/

Хүснэгт 14

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+) Бууралт (-)
Эхний үлдэгдэл	6,397.4	7,248.6	851.2
Нэмэгдсэн	8280	10,203.1	1,923.0
Худалдан авсан	7,293.3	8,706.3	1,413.0
Хандиваар	810.8	1,135.6	324.8
Шилжүүлэн авсан	67.1	229.6	162.5
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	14.6	39.4	24.7
Бусад	94.1	92.0	-2.1
Хасагдсан	7,428.8	9,398.8	1,969.9
Худалдсан, зарцуулсан	7,073.1	8,993.5	1,920.3
Шилжүүлсэн	61.8	21.2	-40.6
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	14.7	9.5	-5.3
Бусад	279	374.5	95.4
Эцсийн үлдэгдэл	7,248.6	8,052.9	804.3

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 8,706.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 1,135.6 сая төгрөг, балансаас баланст 361.0 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, нийт 10,203.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 8,993.5 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулан, 30.7 сая төгрөгийн бараа материалыг баласаас баланст шилжүүлж, 374.5 сая төгрөгийн бараа материалыг акталж, нийт 9,398.8 төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Төсөвт байгууллагын бараа материал салбараар /сая төгрөгөөр/

Хүснэгт 15

Салбар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутаг	1,703.4	1,781.2	+77.8	22.7
Барилга, хот байгуулалтын яам	42.5	20.8	-21.7	0.3
Боловсрол, шинжлэх ухааны яам	4,668.7	4,980.0	+311.3	63.4
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	6.6	6.8	+0.2	0.1
Эрүүл мэндийн яам	631.8	1,067.7	+435.9	13.6
Нийт дүн	7,503.0	7,856.6	+353.6	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын бараа материалын үлдэгдлийн 63.4 хувийг боловсролын салбар, 13.6 хувийг эрүүл мэндийн салбар 22.7 хувийг орон нутаг, 0.4 хувийг бусад салбар эзэлж байна. Боловсролын салбарын байгууллагуудын бараа материалын үлдэгдэл 311.3 сая төгрөгөөр, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бараа материал 435.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материалын өсөлтөд гол нөлөө үзүүлж байна.

Бараа материалтай холбоотой аудитын илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын бараа материалын данстай холбоотой алдаа, зөрчлүүдээс дурдвал:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан материалыг илүү болон дутуу дүнгээр тусгасан, бараа материалын шинжтэй зүйлсийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн, бараа материалыг данс хооронд шилжүүлэн бүртгэсэн зэрэг 63.7 сая төгрөгийн алдааг залруулан, 505.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.
- Тооллогоор бараа материал дутагдуулсан 17.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын дарга хувийн дансаар бэлэн мөнгө авч, үндсэн хөрөнгө болон бараа материал бэлтгэсэн 14.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 127,604.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 130,569.1 сая төгрөг болж, 9,068.6 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө 9,417.8 төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлж байна.

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Хүснэгт 16

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Биет хөрөнгө	121,536.6	130,569.1	9,032.5	95.5
Биет бус хөрөнгө	6,017.1	6,053.2	36.1	4.46
Бусад хөрөнгө	51.0	51.0	-	0.04
Дүн	127,604.7	136,673.3	9,068.6	100
Байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	119,714.8	129,132.6	9,417.8	94.5
ОНӨҮГ	7,889.9	7,540.1	-349.8	5.5
Дүн	127,604.7	136,673.3	9,068.6	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 94.5 хувь буюу 129,132.6 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 5.5 хувь буюу 7,540.1 сая төгрөгийг ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт /сая төгрөгөөр/

Хүснэгт 17

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+) Бууралт (-)
Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл	149,930.17	164,412.7	14,482.53
Нэмэгдсэн	16,986.6	18,596.2	1,609.6
Худалдан авсан	882.2	1,184.9	302.7
Хандиваар	9,135.5	10,901.3	1,765.8
Шилжүүлэн авсан	115.8	2,017.9	1,902.1
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	20.1	1,201.8	1,181.7
Бусад	6,743.6	3,249.7	-3,493.9
Дахин үнэлгээний	89.2	40.3	-48.9
Хасагдсан	2,504.0	3,181.8	677.8
Худалдсан		87.0	87
Акталсан	1,968.2	2,004.7	36.5
Шилжүүлсэн	249.7	992.4	742.7
Бусад	76.9	97.5	20.6
Дахин үнэлгээний хорогдол	209.1		-209.1
Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	164,412.7	179,827.2	15,414.5
Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл	-31,014.5	-36,808.0	-5,793.5
Өмнөх оны элэгдлийн зөрүү	10.8	731.1	720.3
Зардал	7,245.5	6,882.6	-362.9
Элэгдлийн зардал тайлант хугацааны	6,903.8	6,467.2	-436.6
Элэгдлийн зардал бусад	341.6	415.3	73.7
Дансны хасалт	-1,462.8	-1,267.8	195
Бусад	-1,247.3	-1,271.7	-24.4
Дахин үнэлгээний	-215.4	3.8	219.2
Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	-36,808.0	-43,153.9	-6,345.9
Үлдэгдэл өртөг	127,604.7	136,673.2	9,068.5

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,184.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, балансаас баланст шилжүүлэн авсан 4,451.5 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 10,901.3 сая төгрөг, бусад эх үүсвэрээс авсан 3,249.7 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 40.3 сая төгрөг, нийт 18,596.2 сая төгрөгөөр нэмэгдэн, худалдсан 87.0 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 992.4 сая төгрөг, бусад 97.5 сая төгрөг, нийт 3,181.8 сая төгрөгөөр хасагдсан байна.

Биет хөрөнгө дансанд 126,935.2 сая төгрөгийн барилга байгууламж, 7,696.5 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 21,879.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 7,352.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, 9.2 сая төгрөгийн зам, гүүрний байгууламж, 1,264.6 сая төгрөгийн түүх соёл, музейн дурсгалт зүйл, 6,773.8 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 1,653.1 сая төгрөгийн ном бүртгэлтэй байна. Нийт хуримтлагдсан элэгдэл 39,579.9 сая төгрөг байна.

Биет бус хөрөнгө дансанд 334.6 сая төгрөгийн программ хангамж, 5,877.3 сая төгрөгийн бусад биет бус хөрөнгө бүртгэлтэй байна. Нийт хуримтлагдсан элэгдэл 158.7 сая төгрөг байна.

Бусад хөрөнгө дансанд “Шинэ дөрвөлжин” ОНӨААТҮГ-ын 51.0 сая төгрөгийн өөрийн эзэмшлийн газар бүртгэлтэй байна.

Төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө салбараар /сая төгрөгөөр/

Хүснэгт 18

Салбар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутаг	48,068.2	49,487.7	1,419.5	38.3
Барилга, хот байгуулалтын яам	606.3	567.5	-38.8	0.4
Боловсрол, шинжлэх ухааны яам	61,614.6	66,705.8	+5,091.3	51.7
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	412.0	443.8	+31.8	0.3
Эрүүл мэндийн яам	9,013.7	11,927.7	+2,914.0	9.2
Нийт дүн	119,714.8	129,132.6	+9,417.8	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 51.7 хувийг боловсролын салбар, 9.2 хувийг эрүүл мэндийн салбар 38.3 хувийг орон нутаг, 0.7 хувийг бусад салбар эзэлж байна. Боловсролын салбарын байгууллагуудын үндсэн хөрөнгийн үлдэгдэл 5,091.3 сая төгрөгөөр, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2,914.0 сая төгрөгөөр, орон нутгийн байгууллагуудын үндсэн хөрөнгийн үлдэгдэл 1,419.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн хөрөнгийн өсөлтөд гол нөлөө үзүүлж байна.

Тайлант онд төсөвт байгууллагуудын худалдан авсан бие ба биет бус хөрөнгийг салбараар авч үзвэл:

Хүснэгт 19

Салбар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутаг	316.1	479.7	163.6	39.4
Барилга, хот байгуулалтын яам	146.4	25.3	-121.2	2.1
Боловсрол, шинжлэх ухааны яам	332.7	549.6	216.9	45.1
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	-	40.7	40.7	3.3
Эрүүл мэндийн яам	87.0	122.1	35.1	10.0
Нийт дүн	882.3	1,217.3	335.1	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бие ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал өмнөх оноос 335.1 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд бэлтгэсэн 1,217.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн эх үүсвэрээр авч үзвэл: 769.0 сая төгрөгийн хөрөнгийг урсгал төсвөөс, 448.3 сая төгрөгийн хөрөнгийг нэмэлт төсвөөс бэлтгэсэн байна. Орон нутгийн байгууллагууд 479.7 сая төгрөгийн, боловсролын салбар 549.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгөтэй холбоотой аудитын илрүүлэлт:

2021 онд 665.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтуудтай нийцэхгүй байна. Ингэхдээ Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 12 сарын 08-ны өдрийн 1⁹/6368 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлээр Хүүхдийн цэцэрлэгүүдийн хэмнэгдсэн зардлаас 38 цэцэрлэгийн “Багш хөгжлийн төв”-д 314.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн байна.

Мөн 2020 онд төсөвт худалдан авсан 115 байгууллагын 175.2 сая төгрөгийн өртөгтэй “Си Ти Эс” ХХК-ийн санхүүгийн онлайн программын ашиглалтыг шалгахад

хангалтгүй байна. Иймд дээрх алдаа, зөрчлүүдэд салбарын төсвийн төвлөрүүлэн захирагч нарт зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улиастай сумын 9 дүгээр цэцэрлэг бусад биет бус хөрөнгөд бүртгэлтэй газарт 1.1 сая төгрөгийн элэгдэл тооцсон алдааг төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан.

Үндсэн холбоотой аудитын илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын үндсэн хөрөнгийн данстай холбоотой алдаа, зөрчлүүдээс дурдвал:

- Элэгдлийн зардлыг илүү болон дутуу тооцоолсон, бараа материалын шинжтэй зүйлсийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн, аймгийн ИТХ-ын шийдвэргүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн зэрэг 684.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 73.8 сая төгрөгийн алдааг залруулж, 365.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 36.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 32.5 сая төгрөгт төлбөрийн акт тогтоож, Цэцэн-Уул сумын ЗДТГ 5.9 сая төгрөг, Цагаанхайрхан сумын ЗДТГ 7.1 сая төгрөгийн шийдвэргүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2,144.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2,288.3 сая төгрөг төгрөг болж, 143.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Хүснэгт 20

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+) Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	840.1	983.9	143.8	100
Өглөг	215.9	335.5	119.6	34.1
Ажилчидтай холбогдсон өглөг	45.5	71.6	26.1	7.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	162.7	256.3	93.6	26.0
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	7.7	7.7	-	0.8
Бусад өглөг	624.1	648.3	24.2	65.9
Байгууллагад төлөх өглөг	134.1	293.3	159.2	29.8
Хувь хүмүүст төлөх өглөг	12.4	38.2	25.8	3.9
Татварын өглөг /ТӨҮГ/	143.5	87.3	-56.2	8.9
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	28.7	4.6	-24.1	0.5
Дансны өглөг /ТӨҮГ/	305.2	224.7	-80.5	22.8
Урт хугацаат өр төлбөр дүн	1,304.4	1,304.4	-	100
Урт хугацаат зээл	1,304.4	1304,4	-	
ДҮН	2,144.5	2,288.3	143.8	100
Богино хугацаат өр төлбөр байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	318.7	625.3	306.6	63.6
Төрийн сан	41.6	41.6	-	4.2
ОНӨҮГ	479.8	317.0	-162.8	32.2
ДҮН	840.1	983.9	143.8	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийн 625.3 сая төгрөгийн буюу 63.6 хувь нь төсөвт байгууллагын, 41.6 сая төгрөг буюу 4.2 хувь нь төрийн сангийн, 317.0 сая төгрөг буюу 32.2 хувь нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 1,304.4 сая төгрөг бөгөөд тайлант онд нэмэгдээгүй байна. Тус өглөг нь Азийн хөгжийн банкнаас нийтийн ахуй үйлчилгээг дэмжих

чиглэлээр “Амь-Ус трейд” ХХК-ийн авсан урт хугацаат зээл бөгөөд 20 гаруй жилийн насжилттай өглөг байна.

Төсөвт байгууллагын өр төлбөр

Төсөвт байгууллагын өр төлбөр өмнөх оноос 306.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Салбар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутаг	186.7	70.8	-115.9	11.3
Боловсрол, шинжлэх ухааны яам	96.4	227.1	+130.7	36.3
Эрүүл мэндийн яам	35.6	327.4	+291.8	52.4
Нийт дүн	318.7	625.3	+306.6	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын өр төлбөр 291.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ковид-19 цар тахалтай холбоотой үүссэн өглөг байна. Орон нутгийн байгууллагуудын өр төлбөр тайлант онд 115.9 сая төгрөгөөр буурсан байна. Боловсролын салбарын байгууллагуудын өр төлбөр 130.7 сая төгрөгөөр өссөн бөгөөд Улиастай сумын 1 дүгээр цэцэрлэгийн түрээсийн өглөг, Баянтэс сумын цэцэрлэг, Улиастай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн түлш халаалтын өглөг гол нөлөө үзүүлж байна.

Төрийн сангийн өр төлбөр

Аймгийн төрийн санд олон жил он дамжсан, 20 гаруй жилийн насжилттай 41.6 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй өглөг байна.

ОНӨААТҮГ-ын өр төлбөр

ОНӨААТҮГ-ын өр төлбөр өмнөх оноос 162.8 сая төгрөгөөр буурсан байна.

Байгууллагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт + Бууралт -	Дүнд эзлэх хувь
“Амь-Ус трейд” ХХК	81.7	57.0	-24.8	18.0
“Тосон-очирт хайрхан” ОНӨААТҮГ	83.0	36.0	-46.9	11.4
“Очир илч” ОНӨААТҮГ	196.7	204.3	7.6	64.4
Баруун бүсийн тамирчдыг олимпт бэлтгэх төв	116.0	12.3	-103.7	3.9
“Шинэ дөрвөлжин” ОНӨААТҮГ	2.4	7.5	5.1	2.4
Нийт дүн	479.8	317.0	-162.8	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

“Очир илч” ОНӨАТҮГ 7.6 сая төгрөгөөр, “Шинэ дөрвөлжин” ОНӨААТҮГ-ын өглөг 5.1 сая төгрөгөөр өссөн, “Амь-Ус трейд” ХХК-ийн өглөг 24.8 сая төгрөгөөр, “Тосон очирт хайрхан” ОНӨААТҮГ-ын өглөг 46.9 сая төгрөгөөр, Баруун бүсийн тамирчдыг олимпт бэлтгэх төв 103.7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Өр төлбөр холбоотой аудитын илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын өр төлбөр данстай холбоотой алдаа, зөрчлүүдээс дурдвал:

- Цалин болон тогтмол зардлыг авлага, өглөгийн дансаар дамжуулаагүй, авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, тооцоо нийлсэн актын дүнгээс зөрүүтэй тайланд тусгасан 277.9 сая төгрөгийн алдааг залруулж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өглөг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд өссөн 5.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 145,455.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 168,095.5 сая төгрөг болж, өмнөх оноос 22,639.6 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын хувь оролцоо	145,455.9	168,095.5	+22,639.6	
Засгийн газрын оруулсан капитал	57,432.5	59,705.0	+2,272.5	
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	5,798.3	5,921.2	+122.9	
Хуримтлагдсан үр дүн	47,978.6	68,086.4	+20,107.8	
Өмнөх үеийн үр дүн	36,868.3	48,231.3	+11,363.0	
Тайлант үеийн үр дүн	11,110.2	19,855.1	+8,744.9	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,246.5	34,382.9	+136.4	
Дүн	145,455.9	168,095.5	+22,639.6	
Засгийн газрын оруулсан капитал байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	55,344.5	57,617.0	+2,272.5	
ОНӨҮГ	2,088.0	2,088.0	-	
Дүн	57,432.5	59,705.0	+2,272.5	

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал 2020 оны эцэст 57,432.5 сая төгрөг байсан бол тайлант онд 59,705.0 сая төгрөг болж, 2,272.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд Завханмандал, Түдэвтэй, Шилүүстэй сумдын Сум дундын эмнэлэг төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжиж ирсэн болон Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургууль хуучин барилгын газрыг үнэлж, бүртгэсэнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн өмнөх оноос 20,107.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 38,744.9 сая төгрөгөөр, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 252.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.8 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 11,927.6 сая төгрөг, татварын бус орлого 83,993.1 сая төгрөг, тусламж санхүүжилтийн орлого 131,009.1 сая төгрөг, нийт 226,929.8 сая төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Нийт орлого өмнөх оноос 23,228.8 сая төгрөгөөр өссөн нь татварын орлого 2,635.2 сая төгрөгөөр, татварын бус орлого 7,901.4 сая төгрөгөөр, тусламж санхүүжилтийн орлого 7,556.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Мөнгөн гүйлгээний тайлангийн орлого /сая төгрөгөөр/

Хүснэгт 24

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт + Бууралт -	Дүнд эзлэх хувь
Татварын орлого	9,292.3	11,927.6	2,635.3	5.3
Татварын бус орлого	76,091.8	83,993.1	7,901.3	37.0
Тусламж, санхүүжилтийн орлого	118,316.9	131,009.1	12,692.2	57.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	203,701.0	226,929.8	23,228.8	100

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Татварын бус орлогын 83.1 хувь буюу 69,780.5 сая төгрөгийг улсын төсөв орон нутгийн хоорондын шилжүүлгээр, 6 хувь буюу 1,963.0 сая төгрөгийг нийтлэг татварын бус орлогоор, 10.9 хувь буюу 9,164.3 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор бүрдүүлсэн байна.

Тусламж санхүүжилтийн орлогын 52.5 хувь буюу 68,837.1 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр, 5.5 хувь буюу 7,235.6 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтээр, 41.4 хувь буюу 54,230.8 сая төгрөгийг орон нутгийн санхүүжилтээр, 0.5 хувь буюу 705.7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр тус тус бүрдүүлсэн байна.

3.5.9 Зардлын данс

Тайлант онд 183,780.8 сая төгрөгийг урсгал зардалд, 29,590.6 хөрөнгийн зардалд зарцуулсан байна. Нийт зардал өмнөх оноос 13,269.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ТЕЗ-ийн харьяанд 3 сум дундын эмнэлэг, 1 хувийн цэцэрлэг, Соёлын хэлтэс нэмэгдсэн, Биеийн тамир спорт хороо улсын төсөв болон орон нутгийн төсөв гэсэн 2 эх үүсвэрээс санхүүжсэн, улсын төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

Мөнгөн гүйлгээний тайлангийн зарлага /сая төгрөгөөр/

Хүснэгт 25

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт + Бууралт -
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	175,202.1	183,780.7	+8,578.6
УРСГАЛ ЗАРДАЛ	175,202.1	183,780.7	+8,578.6
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,259.6	78,615.3	+5,355.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	44,479.2	47,234.6	-2,755.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,935.4	6,496.4	+2,755.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,107.8	9,403.2	1,295.4
Хангамж, бараа материалын зардал	2,258.9	2,603.7	344.8
Нормативд зардал	2,744.6	2,997.4	252.8
Эд, хогшил, урсгал засварын зардал	381.7	507.1	125.4
Томилолт, зочны зардал	215.6	294.0	78.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	4,010.0	3,553.2	-456.8
Бараа ажил үйлчилгээний зардал	5,126.0	5,525.3	399.3
ТАТААС	27.5	-	-27.5
Хувийн хэвшлийн байгууллагад олгох	27.5	-	-27.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,914.9	105,165.4	3,250.5
Бусад урсгал шилжүүлэг	1,516.4	2,987.3	1,470.9

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт зардлын 42.8 хувь буюу 73,258.6 сая төгрөгийг бараа ажил үйлчилгээний зардал, 57.2 хувь буюу 105,165.4 сая төгрөгийг урсгал шилжүүлэг эзэлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайланд төсөвт байгууллагуудад олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан гүйлгээ, төвлөрүүлэх шилжүүлэг зэрэгтэй холбоотой давхардсан 102,982.0 сая төгрөгийн орлого, зардлын гүйлгээг устгах бичилт хийсэн байна.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зардалтай холбоотой аудитын илрүүлэлт:

Хөдөө, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт зарцуулсан 143.2 сая төгрөгийг төсөвт 6 байгууллага тэтгэвэрт гарахад олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд тайлагнасныг залрууллаа.

Зарцуулалтай холбоотой аудитын илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын зарцуулалттай холбоотой алдаа, зөрчлүүдээс дурдвал:

- Тайлант онд зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, зардал хооронд гүйлгэн зарцуулсан 44.0 сая төгрөгийн алдааг залруулж, 4.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.
- 6 байгууллагын 7 орон тоо илүү ажилласан 36.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, Завсрын аудитаар ажилчдын цалин, НДШ-ийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрсөн 43.5 сая төгрөгийн алдааг залруулж, илүү орон тоо ажиллуулсан зөрчилд 36.8 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлж, цалин илүү олгосон 4.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2 ба түүнээс дээш илүү орон тоо ажиллаж байгаа ажилтнуудыг ажиллуулахгүй байх 66.6 сая төгрөгийн албан шаардлагыг хүргүүлсэн.
- Тайлант онд төсөвт байгууллагууд ажлын дүрэмт хувцас болон биеийн тамирын хувцас бэлтгэсэн, шинэ жил болон хүүхдийн баярын бэлэгт 30.6 сая төгрөгийг зарцуулсан, Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бус, үрэлгэн зарцуулсан зэрэг 2.9 сая төгрөгийн

зөрчилд зөвлөмж, 202.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 33.2 сая төгрөгт төлбөрийн акт тогтоосон.

- Анхан шатны баримтгүй томилолт олгосон, томилолтын хуудсанд ирсэн явсан хугацаа бичигдээгүй, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, томилолтын эх хувьгүй, хуулбарт үндэслэн олгосон, томилолтыг илүү тооцоолсон 18.4 төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 0.9 сая төгрөгийн алдааг залруулж, 5.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 9.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2.6 сая төгрөгт төлбөрийн акт тогтоосон.
- Худалдан авалтын и-баримт бүрдүүлээгүй 250.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 10.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийг сангийн яамнаас 76,979.1 сая төгрөгөөр баталсан бөгөөд аймгийн ИТХ-ын хуралдааны 2020 оны 11 дүгээр тогтоолоор 370.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 77,349.3 сая төгрөгөөр баталсан байна. Дээд шатны төсөвт тодотгол хийгдсэнээр 2021 оны төсвийн тодотголыг аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 17 дугаар тогтоолоор 80,326.2 сая төгрөгөөр баталж, сангийн яамны хянасан дүнгээс 654.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нийт зардлын 46,323.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 27,126.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 515.7 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 5,987.6 сая төгрөгийг ОНХС-аас, 68.2 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 304.4 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 46,323.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 27,126.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 705.7 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас 2,406.2 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зарлагыг 85,079.4 сая төгрөгөөр баталсан бөгөөд 79,923.3 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 93.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв


Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 101 байгууллага 3,759.5 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 78 байгууллага 3,122.9 сая төгрөг, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 6 байгууллага 207.3 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2 байгууллага 113.6 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив, тусламж 3 байгууллага 32.3 сая төгрөг, нийт 7,235.6 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Нэмэлт санхүүжилтээс бараа, үйлчилгээний зардалд 130 байгууллага 3,948.5 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 1 байгууллага 28.8 сая төгрөг,

хөдөө, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 55 байгууллага 856.5 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 31 байгууллага 741.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 28 байгууллага 415.8 сая төгрөг, нийт 5,991.5 сая төгрөгийг зарцуулж, 721.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 19 байгууллага 818.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зарлагыг салбараар /сая төгрөгөөр/



Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.6.1 Аудитын гол асуудал

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг түвшинг мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлогын 226,929.9 сая төгрөгийн 1 хувиар тооцож, 2,269.3 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд ТЕЗ-ийн илэрсэн алдаа 1,037.9 сая төгрөгийн алдаа илэрч тогтоосон материаллаг түвшингээс доогуур байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгөгдлөө. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын алдааг тухай нэгж дээр тооцон холбогдох дүгнэлтүүдийг өгсөн тул давхардуулан тооцоогүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд:

Тайлант хугацаанд оруулбал зохих 156 мэдээллээс 123 мэдээллийг хугацаанд нь, 29 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт мэдээлээгүй, 2 мэдээлэл хугацаа болоогүй, хэрэгжилт нь 95.6 хувьтай байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг оруулаагүй байна.

Төвлөрүүлэн захирагчийн хувьд:

Ургамал сумын Засаг дарга нь тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс 132 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тайлбарын хамт мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлээгүй, мөн төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай мэдээлээгүй, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол мэдээлдэггүй зөрчил илэрсэн.

Төсвийн шууд захирагчийн хувьд:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өмнөх аудитын зөвлөмжийг биелүүлээгүй, хөрөнгө мөнгө зарцуулах аливаа шийдвэр, өр авлага үүссэн тооцоо нийлсэн акт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг тухай бүр, улирлаар болон өссөн дүнгээр мэдээлдэггүй, хугацаа хоцроож мэдээлдэг, хугацаандаа оруулсан ч мэдээллийг үнэн зөв мэдээлдэггүй 1,558.7 сая төгрөгийн зөрчилд 11 заалт бүхий зөвлөмж, 809.9 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлагыг хүргүүлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 заалт бүхий зөвлөмж өгөгдөж, хэрэгжилтийг тооцоход 53.3 хувьтай байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

№	Зөвлөмжийн агуулга	Биелэлт	Хэрэгжилтийн байдал
1	Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг бүрэн хэрэгжүүлж, санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан авлага, өглөгийг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулж үр дүнг дүгнэн ажиллах	60%	2020 оны жилийн эцсийн тайлангаар гарсан сум хөгжүүлэх сангийн авлага болон өглөгт дүн шинжилгээ хийж, 2021 онд авлага, өглөггүй ажиллах чиглэлийг төсвийн төвлөрүүлэн захирагч болон шууд захирагч нартай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.
2	Хөрөнгө бэлтгэхдээ тухайн жилийн Засгийн газрын бодлого чиглэлийг хэрэгжүүлж, ажиллах	50%	Тухайн жилийн төсөвт тусгагдсан зардлын хэмжээгээр хөрөнгө зөвшөөлийг олгож байна. Мөн Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
3	Санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын урьдчилгаа авлагыг барагдуулах, ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах	50%	Байгаль орчин аялал жуулчлалын газар Санхүү эдийн засгийн Их сургуульд аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө хийлгэхээр ажлын урьдчилгаа 40.0 сая төгрөг, “Энх мөнх ирээдүй” ХХК-аар цахилгааны шугам мод үржүүлгийн газар тавих ажлын урьдчилгаа 15.6 сая төгрөгийг олгосон байна. БОАЖГ-аас Санхүү эдийн засгийн сургууль болон “Энх мөнх ирээдүй” ХХК-ийг ажлаа хийж дуусгах талаар албан тоот өгч, шаардлага хүргүүлсэн болно.
Хэрэгжилтийн хувь		53.3%	

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн төрийн санд олон жил он дамжсан, 20 гаруй жилийн насжилттай 153.6 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага, 41.6 сая төгрөгийн өглөг байна.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1,040.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 144.3 сая төгрөгийн алдааг залруулж, 55.6 сая төгрөгийн зөрчилд БОАЖГ-т албан шаардлага, 840.2 сая төгрөгийн зөрчилд салбарын төвлөрүүлэн захирагчдад зөвлөмж хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсөвт 111 байгууллага, Боловсролын салбарын 68, Соёлын салбарын 24, Эрүүл мэндийн салбарын 26, төвлөрүүлэн захирагч 24, ОНӨААН 6, нийт 259 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, төсвийн шууд захирагч 161 байгууллага, төвлөрүүлэн захирагч 24 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 74 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа.

Дүгнэлт гаргасан төсвийн шууд захирагч 161 байгууллагаас 120 байгууллагад “Зөрчилгүй, 31 байгууллагад “Хязгаарлалттай”, 10 байгууллагад “Сөрөг” дүгнэлт, төвлөрүүлэн захирагчийн 24 байгууллагаас 20 байгууллагад зөрчилгүй, 3 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн шууд захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10,263.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,936.4 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 759.9 сая төгрөгийн зөрчилд 95 төлбөрийн акт тогтоож, 2,112.0 сая төгрөгийн зөрчилд 51, хариуцлага тооцуулах 10 албан шаардлага, 3,454.7 сая төгрөгийн зөрчилд 250 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

ТБОНӨААН-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа ОНӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,414.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2.2 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 1.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 7.3 сая төгрөгийн зөрчилд 2, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 1,403.3 сая төгрөгийн зөрчилд 9 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил:

Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 815.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 342.6 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 3.0 сая төгрөгийн зөрчилд 1, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 470.1 сая төгрөгийн зөрчилд 56 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,493.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,281.2 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 761.6 сая төгрөгийн зөрчилд 95 төлбөрийн акт тогтоож, 2,122.3 сая төгрөгийн зөрчилд 54, хариуцлага тооцуулах 12 албан шаардлага, 5,328.1 сая төгрөгийн зөрчилд 315 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд төсөв захирагчид, шинээр томилогдсон нягтлан бодогч нарын төсвийн тухай хуулийн мэдлэг, санхүүгийн сахилга бат сайжруулах, бүртгэлийн ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

4.2.1 Залруулсан алдаа

ТЕЗ-ийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд бусад биет бус хөрөнгөд бүртгэлтэй газарт элэгдэл тооцсон 1.1 сая төгрөгийн, зардлыг зөрүүтэй тайлагнасан 143.2 сая төгрөгийн, нийт 144.3 сая төгрөгийн алдаанд залруулга хийгдсэн.

4.2.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

4.2.3 Албан шаардлага

Аймгийн БОАЖГ-ын 2020 онд үүссэн он дамжсан 55.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар өмнөх оны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Иймд дээрх зөрчилд аймгийн БОАЖГ-т албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

- 2021 онд орон нутгийн төсөвт байгууллагууд 169.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, 2022 оны УИХ-ын 388 тоот тогтоолыг хэрэгжүүлж ажиллах;

2. Хөрөнгийн ашиглалттай холбоотой

2.1 Илрүүлэлт:

- 2020 онд худалдан авсан 175.2 сая төгрөгийн өртөгтэй “Си Ти Эс” ХХК-ийн санхүүгийн программ 2021 онд ашиглалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, УСНББОУС 17-той нийцэхгүй, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

- ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад “Си Ти Эс” санхүүгийн программын ашиглалтад хяналт тавьж ажиллан, 2022 оны санхүүгийн тайланг тус программаар гаргаж ирүүлэх, үр дүнг хянаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Д.БАТ-УНДРАА
АУДИТЫН МЕНЕЖЕР		Б.ДАГВАСҮРЭН
БЭЛТГЭСЭН:		
АХЛАХ АУДИТОР		Б.ЖАЛБАА
АУДИТОР		Ц.ОЮУНСУВД

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр				Нийт зөрчил	Залруулсан		Акт	Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс			
		Түвэрт хамрагдсан	Дүгнэлт				Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
			Зөрчлгүй	Хязгаарлалттай	Сөрөг												
1	Төсвийн ерөнхийлөн захирагч	1			7	1,040.1	2	144.3		1	55.6	4	840.2				
2	Төсвийн төвлөрүүлэн захирагч	20	3	1	68	815.7	11	342.6		1	3.0	56	470.1				
3	Төсвийн шууд захирагч	74	114	31	605	10,263.0	210	3,936.4	94	759.9	51	2,112.0	250	3,454.7			
4	ТБОНӨААТҮГ		5		16	1,414.6	4	2.2	1	1.8	2	7.3	9	1,403.3			
Дүн		74	140	34	696	13,532.3	227	4,424.4	95	761.7	55	2,177.9	319	6,168.3			12